



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Доржсүрэнгийн ҮҮРИЙНТУЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-22-13, Факс: 32-70-16
E-mail: uuriintuya@parliament.mn
http://www.parliament.mn

2025. 06.24 № ЧУХ-03/7433
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ҮҮРИЙНТУЯА

Х.БААСАНЖАРГАЛ

Б.БАЯРБААТАР

Б.УЯНГА

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

00000619



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Доржсүрэнгийн ҮҮРИЙНТУЯА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-22-13, Факс: 32-70-16
E-mail: uuriintuya@parliament.mn
http://www.parliament.mn

2025.06.13 № ИХ-03/7300
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хавсралт ³⁴ хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ҮҮРИЙНТУЯА

Х.БААСАНЖАРГАЛ

Б.БАЯРБААТАР

Б.УЯНГА

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

00000622



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.06.06 № хэт/1635
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Та бүхнээс санаачлан боловсруулсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт ⁰¹ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

М. Мунгайтүвш
Бүдээн санаагаа танингуулах,
Хурийн төлөөт орсон
барих үндсэн, баримт
Бичгийн бичвэрээр, илтгэх
Зууш 11/9.

100255009849

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“9.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нараас санаачлан боловсруулсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нараас санаачлан боловсруулсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах саналыг төсөл санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Монгол Улс 1957 оноос эхлэн Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг нэмэгдүүлэх тухай хуулиар “Алдарт эх” 1, 2 дугаар одонг олгож эхэлсэн бөгөөд 2010 онд батлагдсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг боловсруулах үед “олон хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэг нь хүүхэд төрүүлсэн, өсгөсөн гэсэн 2 утгыг зэрэг хангасан байхаар хуулийн үзэл баримтлалыг тодорхойлон баталсан байдаг.

Өөрөөр хэлбэл уг хуульд заасан урамшууллын гол зорилго нь олон хүүхдийг эсэн мэнд төрүүлж, өсгөж байгаа эхийг алдаршуулахад оршиж байгаа бөгөөд “бага хүүхэд нь 1 нас хүрсэн” гэснийг хасах нь хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна.

2.Одоогийн байдлаар 260 мянга орчим эхэд мөнгөн тусламж олгож байгаа бөгөөд хуулиас “бага хүүхэд нь 1 нас хүрэхэд”, “1 ба түүнээс дээш настай” гэсэн насны зохицуулалтыг хассанаар төсвийн зардлыг нэмэгдүүлэхээр байгааг анхаарах.

Монгол Улсын хувьд төрөлт багасаж байгаатай холбогдуулан хүүхэд төрүүлэхийг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүлийг дэмжих анхдагч хуулийн төслийг боловсруулж байгааг Танд мэдээлэл болгон хүргүүлж байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

ДОРЖСҮРЭНГИЙН ҮҮРИЙНТУЯА

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 5-д “Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангах”, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй...” гэж тус тус заасан.

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд “энэ хуулийн үйлчлэлд дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь нэг нас хүрсэн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцлийг хангасан эх” хамаарна гэж заасан бөгөөд мөн хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан “дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй” гэж заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонг, дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонг олгож байна. Ингэхдээ хамгийн бага хүүхэд нь 1 нас хүрэхэд дөрөв болон зургаагаас дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд үрчлэн авсан хүүхдийг хамруулан олгож байна.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн зохицуулалтаар урамшуулал авах болзолд “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байсан байх” зэрэг нөхцөл тавигдаж байгаа нь хүний эрхийн зөрчил үүсгэж, хүүхдийг насаар нь ялгаварлах гадуурхах нөхцөл бүрдүүлснийг засах шаардлагатай гэж үзлээ.

“Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд тус хуулийн 3 дугаар зүйлийн хэд хэдэн заалтад тусгасан урамшуулал олгох болзлыг хасах буюу хөнгөлөхөөр тусгасан. Тодруулбал,

урамшуулал авахад тавигддаг “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд 1 ба түүнээс дээш настай байх” зэрэг болзлуудыг хасахаар тусгалаа.

Хуулийн төслийн зорилго нь 1 нас хүрээгүй хүүхдээ алдсан эх, хүүхдийн эрхийг хамгаалах, энэхүү урамшуулал, дэмжлэгийн тогтолцоонд хамруулах, хүний эрхэм чанарыг хүндэтгэх, олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг ялгаварлахгүй байх, төрөлтийг дэмжих, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Энэхүү хуулийн төсөл нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийг зөрчиж олон хүүхэд төрүүлсэн эхэд тэгш боломж олгохгүй байгаа, ялгавартай байдлыг арилгахад чиглэж байгаа тул Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөөний суурь зарчимтай нийцэж байна.

Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт дараах зорилтуудыг тусгасан байна. Үүнд:

1. “Алсын хараа-2050” баримт бичгийн Хүн ам ба нийгмийн хөгжил бүлэгт “төрөлтийг дэмжих бодлогыг эрчимжүүлж, олон хүүхэдтэй гэр бүлийг урамшуулах, жендэрийн тэгш байдлыг хангах” зорилтыг тодорхойлсон.

2. “Гэр бүлийн үнэт зүйлийг хадгалах, эх, эцгийн үүргийг бодитоор үнэлэх, хүүхдийн сайн сайхан орчинд өсөн бойжих нөхцөлийг бүрдүүлэх нь хүн төвтэй бодлогын үндэс суурь” гэж бодлогын баримт бичигт тусгасан.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж, хүүхдийн эрхийг хамгаалах, хүн ам зүйн тогтвортой өсөлт, гэр бүлийн хамгааллыг дэмжих, хүүхдийн хөгжил, хамгааллын орчныг бүрдүүлэх үндэсний зорилтод чиглэж буй бодлогын баримт бичгийн нэг хэсэг болж байна. Монгол Улсын хүн амын өсөлтийг дэмжих, эх, үрсийн эрхийг хамгаалах төрийн бодлоготой нийцүүлэн хуульд энэхүү өөрчлөлтийг оруулах шаардлагатай гэж үзлээ.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төсөл нь 2 зүйлтэй байх бөгөөд Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгүүдэд тавьсан шаардлагуудад хасалт хийж, хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Монгол Улсад жил бүр дунджаар 75,000–80,000 хүүхэд шинээр мэндэлдэг бөгөөд нийт төрөлтийн 3–4 орчим хувьд хүүхэд 1 нас хүрэхээс өмнө нас барж, мөн тооны ээжүүд эхийн алдар одон болон одонгийн урамшуулалд хамрагдаж чаддаггүй байна. Энэ нь ойролцоогоор жилд 2,500-3,000 эх хуулийн хязгаарлалтын улмаас тэгш эрх эдлэх боломжоо алдаж байна. Хуулийн төсөл батлагдсанаар өмнө урамшуулал авч чадаагүй 27,000 гаруй эхийн хувьд дахин судлагдаж, урамшуулалд хамрагдах боломжтой болно.

Ийнхүү энэ хуулийн төсөл нь зөвхөн ирээдүйд төрөх эхчүүдэд бус, өмнөх хугацаанд эрхээ эдэлж чадаагүй эхчүүдэд ч тэгш эрхийн боломжийг нээж, эх үрсээ дэмжих төрийн бодлогын хүртээмжийг бодитойгоор нэмэгдүүлэх юм.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Хууль тогтоомжийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно. Хууль хэрэгжихтэй холбогдуулан шинээр хууль боловсруулах бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.

---o0o---

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 5-д “Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангах”, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй...” гэж тус тус заасан.

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд “энэ хуулийн үйлчлэлд дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь нэг нас хүрсэн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцлийг хангасан эх” хамаарна гэж заасан бөгөөд мөн хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан “дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй” гэж заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонг, дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонг олгож байна. Ингэхдээ хамгийн бага хүүхэд нь 1 нас хүрэхэд дөрөв болон зургаагаас дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд үрчлэн авсан хүүхдийг хамруулан олгож байна.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн зохицуулалтаар урамшуулал авах болзолд “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байсан байх” зэрэг нөхцөл тавигдаж байгаа нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийг зөрчиж, хүүхдийг насаар нь ялгаварлах гадуурхах нөхцөл бүрдүүлснийг засах, хүний эрхэм чанарыг хүндэтгэх төрийн үүргийг хангах шаардлагатай байгаа тул “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулав.

Энэхүү хуулийн төсөлд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд урамшуулал олгох шалгуурыг багасгах буюу хөнгөлөхөөр тусгасан. Тодруулбал, урамшуулал авахад тавигддаг “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд 1 ба түүнээс дээш настай байх” зэрэг шаардлагуудыг хасахаар тусгалаа.

Хуулийн төслийн зорилго нь 1 нас хүрээгүй хүүхдээ алдсан эхчүүдийн эрхийг хамгаалах, энэхүү урамшуулал, дэмжлэгийн тогтолцоонд хамруулах,

олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг ялгаварлахгүй байх, төрөлтийг дэмжих, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, нас барсан хүүхдийг хамруулахаар эрх зүйн зохицуулалтыг тусгав.

---o0o---

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 5-д “Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй””, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангах”, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй...” гэж тус тус заасан.

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд “энэ хуулийн үйлчлэлд дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь нэг нас хүрсэн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцлийг хангасан эх” хамаарна гэж заасан бөгөөд мөн хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан “дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй” гэж заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонг, дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонг олгож байна. Ингэхдээ хамгийн бага хүүхэд нь 1 нас хүрэхэд дөрөв болон зургаагаас дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд үрчлэн авсан хүүхдийг хамруулан олгож байна.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн зохицуулалтаар урамшуулал авах болзолд “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байсан байх” зэрэг нөхцөл тавигдаж байгаа нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийг зөрчиж, хүүхдийг насаар нь ялгаварлах гадуурхах нөхцөл бүрдүүлснийг засах, хүний эрхэм чанарыг хүндэтгэх төрийн үүргийг хангах шаардлагатай байгаа тул “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулав.

Энэхүү хуулийн төсөлд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд урамшуулал олгох шалгуурыг багасгах буюу хөнгөлөхөөр тусгасан. Тодруулбал, урамшуулал авахад тавигддаг “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд 1 ба түүнээс дээш настай байх” зэрэг шаардлагуудыг хасахаар тусгалаа.

Хуулийн төслийн зорилго нь 1 нас хүрээгүй хүүхдээ алдсан эхчүүдийн эрхийг хамгаалах, энэхүү урамшуулал, дэмжлэгийн тогтолцоонд хамруулах, олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг ялгаварлахгүй байх, төрөлтийг дэмжих, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хуулийн төсөлд

Хуулийн төсөл 2 зүйлтэй бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгав. Үүнд:

1. Төслийн 1 дүгээр зүйлд хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, нас барсан хүүхдийг хамруулахаар тусгав.

2. Төслийн 2 дугаар зүйлд хууль хэрэгжиж эхлэх хугацааг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс байхаар тусгав.

Энэхүү төсөл батлагдсанаар “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон авах эхчүүдийн тоо 10,154 хүнээр, 2 дугаар зэргийн одон авах эхчүүдийн тоо 27,140 хүнээр нэмэгдэж, 7.5 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэрийг улсын төсөвт тусгах шаардлагатай болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйл, заалтад тандан судалгаа хийв.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсгээс "бага хүүхэд нь 1 нас хүрсэн" гэснийг, 3.2 дахь хэсгээс "бага хүүхэд нь 1 нас хүрэхэд", "байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас", "1 ба түүнээс дээш настай" гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

2025 он

АГУУЛГА

1. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал
3. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулан судалсан байдал
4. Дүгнэлт, зөвлөмж

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 5-д “Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй””, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй...” гэж тус тус заасан.

Манай улс төрөлтийг дэмжих, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор залуу үеийг өсгөн хүмүүжүүлэхэд гавьяа байгуулсан олон хүүхэдтэй эхчүүдийг шагнаж байхаар БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор анх 1957 онд “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай” хуулийг баталж, “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгуудыг бий болгож байсан. Энэхүү анхны хууль нь 4 зүйлтэй байснаас 1 дүгээр зүйл буюу Эхийн алдар нэг, хоёрдугаар зэргийн одон бий болгосон шийдвэр нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр байгаа бөгөөд 2 дугаар зүйлийг 2010 онд, 3 болон 4 дүгээр зүйлүүдийг 1962 онд тус тус хүчингүй болгожээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль 2010 онд шинээр батлагдсан. Энэ хуулинд 2011 онд болон 2024 онд нийт 2 удаа нэмэлт хийсэн байна.

Энэхүү хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд “энэ хуулийн үйлчлэлд дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь нэг нас хүрсэн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцлийг хангасан эх” хамаарна гэж заасан бөгөөд мөн хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан “дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй” гэж заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонг, дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонг олгож байна. Ингэхдээ хамгийн бага хүүхэд нь 1 нас хүрэхэд дөрөв болон зургаагаас дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд үрчлэн авсан хүүхдийг хамруулан олгож байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд төрөлтийн хурд буурч байна. Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод хүн амын өсөлтийг жил тутамд 1.7 хувиас багагүй байхаар, 2050 он гэхэд 5 сая хүн амтай болно гэж төлөвлөсөн. Гэтэл сүүлийн жилүүдэд хүн амын өсөлтийн хурд унаж 2020 онд 1.8 хувь байсан бол 2023 онд 1.4 хувь, 2024 онд 1.1 хувь болж, 5 жилийн дотор 0.7 функтээр буурсан байна. Энэхүү статистик үзүүлэлтээс харахад 2050 онд манай улс 5 сая хүн амтай болох боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Хүн ам зүйн чиглэлийн эрдэмтэн судлаачдын хийсэн судалгаагаар манай улс хүн ам зүйн шилжилтийн 3 дугаар үе шатанд байгаа бөгөөд төрөлтийн хурд буурч байгаа энэ нөхцөл байдал хэвээр үргэлжилбэл 2030 он гэхэд насжиж буй нийгэмтэй болох эрсдэлтэй байна. Төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) 1980 онд 6 байсан бол 1990 онд 4.5, 2020 онд 2.9, 2024 онд 2.5 болж буурсаар байна. Энэ байдлаар үргэлжилбэл 2032 он гэхэд ТНК 2 гэсэн түвшинд хүрч цаашид өсөлтгүй тогтвортой буурах нөхцөл үүсэхээр байгааг судлаачид тооцсон байна. Манай улсын ТНК 2005 онд сүүлийн 30 жилийн хугацаан дахь хамгийн бага түвшиндээ хүрч 1.95 хувь болж буурч байсан. Энэ үед хүн амын өсөлтийг дэмжих чиглэлээр олон арга хэмжээг мөнгөн урамшуулал хэлбэрээр авч хэрэгжүүлсэн. Шинэ гэр бүлд 500,000 төгрөг олгох, шинээр төрсөн хүүхдэд мөнгөн тэтгэмж олгох гэх мэт. Энэ шийдлийг тодорхой судалгаа тооцоонд үндэслээгүйгээс 2012 оноос шинэ гэр бүлд олгодог мөнгөн тэтгэмжийг цуцалсан байдаг. Эдгээр арга хэмжээний үр дүнд төрөлт тодорхой хэмжээгээр нэмэгдсэн ч эдгээр нь урт хугацааны тогтвортой бодлого болон хэрэгжиж чадаагүй байна.

Хүн амын өсөлтийн хурдыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл нь мөнгөн урамшууллаас гадна сэтгэл зүйн нөлөө их чухал байгааг судлаачид гаргажээ.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад хүн амын өсөлтийг дэмжих, амьдралын чанарыг дээшлүүлэх талаар олон зохицуулалт байдаг хэдий ч эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээ хийгдэж байгаагүй нь өнгөрсөн хугацаанд гаргасан бодлого үр дүнтэй байсан эсэхийг дүгнэх боломжгүй болгож байна.

Хүн амын өсөлтийн хурдын динамик үзүүлэлтийг сүүлийн 70 жилээр гарган тухайн цаг үед гаргаж байсан төр засгийн бодлоготой уялдуулан судлахад 1956 онд манай улс 845,500 хүн амтай байсан бол 1962 онд нэг сая дахь иргэнээ, 1988 онд 2 сая дахь иргэнээ, 2015 онд 3 сая дахь иргэнээ бүртгэж, сүүлийн 50 жилд хүн ам хоёр саяар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд 1957 онд батлагдсан “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай” хууль дорвитой нөлөө үзүүлсэн хүчин зүйлсийн нэг байжээ гэж дүгнэж болохоор байна. Харин сүүлийн 10 жилд 500 гаруй мянгаар хүн ам өссөн байна.

Эндээс дүгнэхэд хүн амын өсөлтийг дэмжихэд монгол хүний сэтгэл зүйн онцлогт тохирсон урт хугацааны тогтвортой бодлого шаардлагатай байна. Тиймээс 1957 оноос хойш хэрэгжиж байгаа олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг урамшуулах асуудлыг зохицуулсан хууль эрх зүйн орчныг илүү хүртээмжтэй болгох нь хүн амын өсөлтөд хувь нэмрээ оруулна гэж үзэн нэмэлт оруулахаар бэлтгэсэн.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Судалгааны эхний хэсэгт тодорхойлсон асуудал, түүний үүсгэж буй шалтгаан нөхцлийг арилгах арга замын хувилбарыг зорилгод хүрэх байдал, зардал үр өгөөж, үр нөлөөний байдлаар дараах байдлаар харьцуулан үзэв.

2.1 Асуудлыг зохицуулах хувилбар

2.1.1. “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;

2.1.2. Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх;

2.1.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх;

2.1.4. Төрөөс санхүүгийн интевенц хийх;

2.1.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх

2.1.6. Захиргааны шийдвэр гаргах;

2.1.7. Хуулийн төсөл боловсруулах;

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “ЭХИЙН АЛДАР” нэгдүгээр зэргийн одон, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “ЭХИЙН АЛДАР” хоёрдугаар зэргийн одонг олгож байна. Ингэхдээ хамгийн бага хүүхэд нь нэг нас хүрэхэд 4 болон 6-аас дээш хүүхэдтэй байсан бөгөөд эдгээр хүүхдийн тоонд 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхдийг хамруулан олгож байгаа. Энэ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэхэд зөвхөн хуульд өөрчлөлт оруулах, зөвхөн хуулиар зохицуулах шаардлагатай болно.

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулж тоймлон үзвэл:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Тэг хувилбар	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал гарахгүй боловч асуудлаас үүдэн бий болж байгаа сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнгүй
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Боломжгүй.	Зардал үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй

Төрөөс санхүүгийн интервенци хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Захиргааны шийдвэр гаргах	Асуудал нь хуулийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд захиргааны шийдвэр гаргах замаар шийдвэрлэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Үүсээд байгаа шалтгаан нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд хуулийн хүчин чадлаас дээгүүр захиргааны шийдвэр гарахгүй тул зардал, үр өгөөж тооцох боломжгүй	Үр дүнгүй
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хуулийн зохицуулалтын дагуу 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонг олгож байгаа бөгөөд ингэхдээ хамгийн бага хүүхэд нь нэг нас хүрэхэд 4 болон 6-аас дээш хүүхэдтэй байсан бөгөөд эдгээр хүүхдийн тоонд 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас	7.5 орчим тэрбум төгрөгийн зардал нэмэлтээр гарах ч энэ нь дотоодын эдийн засгийг дэмжих, үр өгөөжтэй зардал гэж тооцож болно.	Үр дүнтэй

	нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхдийг хамруулан олгож байгаад нэг нас хүртэл гэдэг хязгаарыг хассанаар хуулийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлэх боломжтой.		
--	--	--	--

Хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон эерэг ба сөрөг талыг зардал, үр өгөөжөөр харьцуулсны үр дүнд “хуулийн төсөл боловсруулах” нь асуудлыг шийдвэрлэх ганц хувилбар байгаа нь хууль гаргах хэрэгцээ, шаардлагатай гэж үзсэн.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН БАЙДАЛ

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нийцлийг дараах байдлаар нарийвчлан судаллаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуультай нийцсэн нийцэл,
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө,
- Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцсэн нийцэл.

3.1. Монгол Улсын Үндсэн хуультай нийцсэн нийцэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 5-д “Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасантай нийцэж байна.

3.2. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Хүний амьд явах, нийгмийн халамж, хамгаалалд адил тэгш хамрагдах эрх хангадана. Ялангуяа олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдийн хөдөлмөр ялгаваргүйгээр үнэлэгдэж, тэдний эрх ашгийг дэмжсэн нийгмийн бодлого хэрэгжинэ.

Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүй, хүүхэд төрүүлж өсгөх хөдөлмөрийг ялгаваргүй үнэлсэн бодлого нь нийгмийн хандлагыг өөрчилж, хүн амын өсөлтийг дэмжих хөшүүргийн нэг болно.

Урьдчилсан тооцоогоор 2026 онд 10 мянга орчим эх шинээр, 27 орчим мянган эх одонгийн зэрэг ахиж, энэхүү хуулийн үйлчлэлд нэмэлтээр хамрагдах боломжтой. Хэрэв нэг эхэд 200,000 төгрөгийн урамшууллын зардал гарах бөгөөд нийт 7.5 тэрбум орчим төгрөгийн төсөв шаардагдана.

Энэ хөрөнгө оруулалт нь нийгмийн зорилтот бүлгийн хэрэглээг дэмжсэн, богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд орох магадлалтай, үр ашигтай зардал гэж үзэж болно.

Хууль батлагдсанаар байгаль орчинд шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Хувилбар	Эерэг тал	Сөрөг тал
Одоогийн хууль хэвээр хадгалах	Төсвийн ачаалал нэмэгдэхгүй	Тэгш хүртээмж хангагдахгүй, гомдол нэмэгдэнэ
Шалгуур зөөллөх (төсөлд туссан хувилбар)	Тэгш хандлага бий болно, төрөлт дэмжигдэнэ	Урамшууллын зардал нэмэгдэнэ.
Урамшууллыг нэмэгдүүлэх + шалгуурыг зөөллөх	Илүү олон эхчүүд хамрагдаж, нийгмийн урамшуулал нэмэгдэнэ	Төсөвт мэдэгдэхүйц дарамт үүсгэнэ

Тиймээс шалгуурыг зөөллөх зорилго бүхий хуульд өөрчлөлт нь илүү зохимжтой байна.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй болно.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах хувилбарыг аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дараах байдлаар дүгнэв:

Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбар: Хууль гаргах
Зорилгод хүрэх байдал	Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас

	нас барснаас бусад тохиолдлуудыг оруулан тооцохоос гадна 0-1 насандаа нас барсан хүүхдийг хамруулах.
Хүний эрх, эдийн засаг байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Эерэг нөлөөтэй, сөрөг нөлөөгүй.
Зардал үр өгөөжийн харьцаа	Жилд 7.5 орчим тэрбум төгрөгөөр урамшууллын зардал нэмэгдэхээр байна. Төрөлтийг дэмжих чиглэлээр мөнгөн урамшуулал олгодог бодлого нь хүн амын өсөлтөд нөлөөлдөг хүчин зүйлсийн 15 хувийн нөлөөлөл үзүүлдэг болохыг судлаачид тооцож гаргасан байна.
Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Байхгүй.
Хууль тогтоомжтой нийцтэй эсэх	Нийцтэй.
Тухайн зохицуулалтаар хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Олон хүүхэд төрүүлж өсгөж буй эх.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургаадугаар зүйлийн 5-д Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан бөгөөд Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж дөрөв болон түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд нас барсан “0-1 насанд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас бусад тохиолдлууд” хүүхдийг хамруулахаар Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагатай болохыг дүгнэлээ.

---oOo---

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

НЭГ. Ерөнхий мэдээлэл

Хуулийн нэр: Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

Хуулийн төслийн зорилго: “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай” хуульд заасан нэг нас хүрсэн гэсэн насны хязгаарлалт, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхдийг хамруулах шаардлагуудыг хүчингүй болгох, ингэснээр олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг ялгаварлахгүй, бодит нөхцөл байдалд нийцүүлэн урамшуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хуулинд урамшуулал авах эрх нь тодорхой нөхцөл, болзлоор хязгаарлагдаж байсан бол шинэ өөрчлөлт нь эхчүүдэд тэгш боломж олгож, эрхийн ялгавартай байдлыг арилгахад чиглэж байгаа нь Үндсэн хуулийн тэгш байдлын зарчимтай нийцэж байна.

Хуулийн хэрэгжих хүрээ: Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч буй олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдэд үйлчлэх бөгөөд тухайн эхчүүдэд олгох урамшуулал, хөнгөлөлт, үйлчилгээ нь хуульд заасан нөхцөл шаардлагыг хангаж буй тохиолдолд хамаарах болно.

Хуулийн хэрэгжилтийг хангах, энэхүү хуульд заасан урамшуулал, хөнгөлөлт, үйлчилгээний хүртээмжийг бүх нийтэд тэгш, шударгаар хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд хариуцах бөгөөд хуулийн дагуу тодорхой хяналт тавигдана.

ХОЁР. Зардлын тооцоо

ТООЦООЛЛЫГ ХИЙХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ. 2023 оны байдлаар энх тунх байгаа 2,3,4,5-н хүүхэдтэй эхчүүдийн хувьд 0-1 насандаа нас барсан хүүхэдтэй байх хувийг тодорхойлох замаар "Алдарт эхийн I, II" одон авах болзлыг хангах эхийн тоог тодорхойлох.

Ингэхдээ нас барсан хүүхдийг нэмж оруулснаар шинээр алдарт эхийн II-р одон авах болзол хангах, II-р одонтой эхээс I-р одонтой эх рүү шилжих тооцооллыг дараах байдлаар хийлээ. Үүнд,

2023 оны байдлаар 2 хүүхэд нь энх тунх, 2 хүүхэд нь 0-1 насандаа нас барсан хүүхэдтэй байх эхийн магадлал (II-р зэргийн одон шинээр авах ээжүүдийг тооцоолох)

2023 оны байдлаар 3 хүүхэд нь энх тунх, 1 хүүхэд нь 0-1 насандаа нас барсан хүүхэдтэй байх эхийн магадлал (II-р зэргийн одон шинээр авах ээжүүдийг тооцоолох)

2023 оны байдлаар 3 хүүхэд нь энх тунх, 2 хүүхэд нь 0-1 насандаа нас барсан хүүхэдтэй байх эхийн магадлал (II-р зэргийн одон шинээр авах ээжүүдийг тооцоолох)

2023 оны байдлаар 4 хүүхэд нь энх тунх, 1 хүүхэд нь 0-1 насандаа нас барсан хүүхэдтэй байх эхийн магадлал (Энэ бүлэг өөрчлөлтгүй тул тооцоонд ашиглагдахгүй)

2023 оны байдлаар 4 хүүхэд нь энх тунх, 2 хүүхэд нь 0-1 насандаа нас барсан хүүхэдтэй байх эхийн магадлал (II-р одонгоос I-р одон руу шилжих ээжүүдийг тооцоолох)

2023 оны байдлаар 5 хүүхэд нь энх тунх, 1 хүүхэд нь 0-1 насандаа нас барсан хүүхэдтэй байх эхийн магадлал (II-р одонгоос I-р одон руу шилжих ээжүүдийг тооцоолох)

АШИГЛАСАН ӨГӨГДӨЛ. ҮСХ-ноос зохион байгуулан явуулсан Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС)-ны 2023 оны судалгааны 15-49 насны эмэгтэйчүүдийн асуулгын төрөлтийн түүх бүлгийн мэдээллийг гол эх үүсвэр болгон ашигласан. Мөн нэмэлт эх үүсвэрээр хүн ам, эрүүл мэндийн статистик мэдээллийг ашиглав.

ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ. Тоон мэдээллийн бэлэн байдалтай холбоотойгоор дараах хязгаарлалтууд байсан. Үүнд,

Нас барсан шалтгааныг байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсныг шалгах боломжгүй тул бүх шалтгааны хувьд авч үзсэн.

ҮСХ-нд байгаа захиргааны (хүн амын төрөл, нас баралт, эрүүл мэнд гэх мэт) мэдээллүүд нь ихэвчлэн улсын түвшний нэгтгэл мэдээллүүд байдаг тул дотор нь хүүхдийн насаар гэх мэтээр нарийвчлан авч үзэх боломжгүй. Мөн дээрх шалтгаанаар Монгол Улсын бүх хүүхэдтэй эхчүүд болон тухайн эхчүүдийн хүүхэд нь нас барсан эсэх, эхчүүдийн түвшинд нас барсан хүүхдийн тоон мэдээллийг ялгаж гаргахгүй тул шууд захиргааны мэдээллээс нарийвчилсан үр дүнг гаргах боломжгүй болсон.

► НҮТС нь зөвхөн 15-49 насны эмэгтэйчүүдийн төрөлтийн түүхийг асуусан тул 50, түүнээс дээш насны эхчүүдийн үр дүнг шууд тооцох боломжгүй байсан.

► Нас баралт нь түгээмэл тохиолдох ажиглалт биш тул түүвэр судалгааны алдааны хувь өндөр, хэлбэлзэл ихтэй үр дүн тооцогдсон.

► НҮТС нь хамгийн сүүлд 2023 онд зохион байгуулагдсан тул тооцооллыг 2023 оноор авч үзсэн.

АЛДАРТ ЭХИЙН II ОДОН ШИНЭЭР, I ОДОН РУУ ШИЛЖИХ ЭХЧҮҮДИЙН ТООГ ТООЦОХ НЬ

АЛХАМ 1. 15-49 насны энх тунх 2-5 хүүхэдтэй эхчүүдийн 0-1 насандаа нас барсан хүүхдийг тооцсоноор I, II-р одон авах болзол хангах магадлалыг тооцох

Тооцооллыг НҮТС-2023 судалгааны “Төрөлт, төрөлтийн түүх” бүлгийн мэдээллийг ашиглан тооцсон. Энэ бүлэг нь 15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд бүх төрөлтийн түүхийг асуусан ба тухайн төрсөн хүүхэд нь энх тунх амьдарч байгаа эсэх, үгүй бол хэдэн насандаа нас барсан талаар асуултад үндэслэн тооцооллыг хийсэн.

2023 оны байдлаар энх тунх байгаа 2,3,4,5-н хүүхэдтэй эхчүүдийн хувьд **0-1 насандаа** нас барсан хүүхэдтэй байх хувь болон 95-н хувийн түвшинд итгэх завсрын утгыг тооцов (Хүснэгт1).

Хүснэгт 1. 15-49 насны энх тунх 2-5 хүүхэдтэй эхчүүдийн 0-1 насандаа нас барсан хүүхдийг тооцсоноор I, II-р одон авах болзол хангах магадлал

Үзүүлэлт	Магадлалын хувь (... тооны хүүхэдтэй эхчүүдийн нас барсан хүүхэдтэй байх хувь)	95%-ийн итгэх түвшинд хэлбэлзэл	
		Доод	Дээд
2 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.03%	0.01%	0.12%
3 хүүхэд амьд & 1 хүүхэд нас барсан (0-1)	1.09%	0.88%	1.37%
3 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.13%	0.07%	0.25%
4 хүүхэд амьд & 1 хүүхэд нас барсан (0-1)	0.92%	0.72%	1.17%
4 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.14%	0.07%	0.26%
5 хүүхэд амьд & 1 хүүхэд нас барсан (0-1)	0.24%	0.15%	0.39%

Эх үүсвэр. НҮТС-2023, судлаачийн тооцооллоор

Тайлбар. НҮТС-2023 оны үр дүнгээс 1 эх хамгийн ихдээ 2 хүүхдээ алдсан тохиолдол бүртгэгдсэн байсан тул нас барсан хүүхдийн тоог 1,2-оор тооцсон.

Хүснэгтийн утгыг ойлгох нь. Жишээлбэл, одоо энх тунх 2 хүүхэдтэй эхчүүд дунд 2 хүүхдээ ямар нэг шалтгаанаар алдсан байгаа хувь дунджаар 0.03% буюу энэ нь 95 хувийн итгэх мужийг харгалзан үзвэл багадаа 0.01%, ихдээ 0.12% байна.

АЛХАМ 2. Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар нийт хүүхэд төрүүлсэн 15-49 насны эхчүүдийн тоог тооцох

НҮТС-ны 2023 оны үр дүнгээр 15-49 насны эмэгтэйчүүдийн 82.2 хувь нь хамгийн багадаа 1 хүүхэд төрүүлдэг байна. Эндээс Монгол Улсын 15-49 насны нийт 883,615 эмэгтэйчүүдийн 82.2 хувь нь хүүхэд төрүүлсэн гэж үзвэл нийт 725,978 эмэгтэй хамгийн багадаа 1 хүүхэд төрүүлсэн байна.

АЛХАМ 3. Алхам 1-д тооцсон магадлалын хувийг ашиглан 2023 оны байдлаар 15-49 насны шинээр/шилжиж Алдарт эхийн одон авах эхчүүдийн тоог тооцох.

Нийт хүүхэд төрүүлсэн 15-49 насны 725,978 эхчүүдийн хувьд хүснэгт 1-н магадлалыг ашиглан хэд нь шинээр II-р одон авах болзол хангах, хэд нь II-р одонгоос I-р одон руу шилжих эхийн тоог тооцоолсон.

Тооцооллын дүнгээр 15-49 насны нийт 12,583 эх шинээр II-р одон авах болзол хангах, 4,708 эх II-р одонгоос I-р одон руу шилжихээр байна (Тооцооллын 95-н хувийн магадлалын итгэх интервалын дээд утгаар тооцсон).

Хүснэгт 2. 15-49 насны шинээр II-р одон авах болзол хангах, II-р одонгоос I-р одон руу шилжих эхчүүдийн тоо (тооцооллоор)

Үзүүлэлт	Магадлалын хувь	Эхчүүдийн тоо	Тайлбар
2 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.12%	866	II одон шинээр авах
3 хүүхэд амьд & 1 хүүхэд нас барсан (0-1)	1.37%	9,928	II одон шинээр авах
3 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.25%	1,789	II одон шинээр авах
4 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.26%	1,880	I одон руу шилжих
5 хүүхэд амьд & 1 хүүхэд нас барсан (0-1)	0.39%	2,827	I одон руу шилжих
Нийт		17,291	

АЛХАМ 4. 50, түүнээс дээш насны энх тунх 2-5 хүүхэдтэй эхчүүдийн нас барсан хүүхдийг тооцсоноор одон авах болзол хангах магадлалыг тооцох

Алхам 1-д дурдсан ялгаатай тооны хүүхэдтэй 50, түүнээс насны эхчүүдийн хувьд нас барсан хүүхэдтэй байх магадлалыг тооцохдоо 50, түүнээс дээш болон 15-49 насны эмэгтэйчүүдийн төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК)1- ийн харьцааг ашиглан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд тооцсон магадлал тус бүрийг үржүүлж тооцсон.

ТНК харьцааг тооцохдоо 15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд 1991-2023 оны хооронд хүүхэд төрүүлсэн гэж үзэн 1991-2023 оны дундаж ТНК (2.7)-ийг, 50, түүнээс дээш настай эмэгтэйчүүдийн хувьд тоон мэдээллийн бэлэн байдлыг харгалзан 1950-1990 оны дундаж ТНК (6.4)-ийг ашиглан тооцсон.

ТНК харьцаа=6.4 (50-аас дээш насны эмэгтэйчүүдийн дундаж ТНК) / 2.7(15-49 насны эмэгтэйчүүдийн дундаж ТНК) =2.38

¹Төрөлтийн нийлбэр коэффициент гэдэг нь нэг эмэгтэйн (нөхөн үржихүйн амьдралын хугацаагаа дуустал нас барахгүй гэж үзвэл) нөхөн үржихүйн амьдралынхаа сүүл үе гэхэд төрүүлсэн байх нийт хүүхдийн тоог илэрхийлнэ. Төрөлтийн нийлбэр коэффициентийг бүх эмэгтэйчүүдийн тухайн цаг үе дэх төрөлтийн тоог нэгтгэн нэг эмэгтэйд ногдохоор тооцдог.

² Судалгааны мэдээлэл нь зөвхөн 15-49 насны эмэгтэйчүүдийг судалгаанд хамруулах тул 50, түүнээс дээш насны хүн амын хувьд Алхам 1-тэй ижил тооцооллыг гаргах боломжгүй юм. Тиймээс бидний хувьд 2023 оны байдлаар 50, түүнээс дээш настай эхчүүдийн нас баралт өндөр байсан гэсэн таамаглал дэвшүүлж, алхам 4-ын магадлалыг шууд ашиглахгүй, тодорхой тогтмол коэффициентээр нэмэгдүүлсэн.

Хүснэгт 3. 50, түүнээс дээш насны энх тунх 2-5 хүүхэдтэй эхчүүдийн 0-1 насандаа нас барсан хүүхдийг тооцсоноор одон авах болзол хангах магадлал

Үзүүлэлт	15-49 насны эхчүүдийн магадлалын хувь (... тооны хүүхэдтэй эхчүүдийн нас барсан хүүхэдтэй байх хувь)	ТНК-ийн харьцаа 2.38	50, түүнээс дээш насны эхчүүдийн магадлалын хувь (... тооны хүүхэдтэй эхчүүдийн нас барсан хүүхэдтэй байх хувь)
	a	b	c=a*b
2 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.12%	2.38	0.28%
3 хүүхэд амьд & 1 хүүхэд нас барсан (0-1)	1.37%	2.38	3.26%
3 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.25%	2.38	0.59%
4 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.26%	2.38	0.62%
5 хүүхэд амьд & 1 хүүхэд нас барсан (0-1)	0.39%	2.38	0.93%

Эх үүсвэр. Судлаачийн тооцооллоор

Тайлбар. 50, түүнээс дээш насны хүн ам нь 15-49 насныхантай харьцуулахад илүү өндөр магадлалтай хүүхэд төрүүлдэг тул эдгээр хоёр насны бүлэг дэх ТНК-ийн харьцаатай ижил түвшнээр эхчүүдийн хүүхдээ алдсан байх магадлал өндөр гэж таамагласан.

АЛХАМ 5. Монгол улсын хэмжээнд 2023 оны байдлаар нийт хүүхэд төрүүлсэн 50, түүнээс дээш насны эхчүүдийн тоог тооцох

50, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 97.2 (судлаачийн таамаглал) хувь нь хамгийн багадаа 1 хүүхэд төрүүлсэн гэж үзвэл Монгол Улсын 50, түүнээс дээш насны нийт 362,931 эмэгтэйчүүдийн 352,624 эмэгтэй хамгийн багадаа 1 хүүхэд төрүүлсэн байна.

АЛХАМ 6. Алхам 4-д тооцсон магадлалын хувийг ашиглан 2023 оны байдлаар 50-аас дээш насны шинээр/шилжих Алдарт эхийн одон авах эхчүүдийн тоог тооцох

Нийт хүүхэд төрүүлсэн 50, түүнээс дээш насны 352,624 эмэгтэйчүүдийн хувьд хүснэгт 3-н магадлалыг ашиглан хэд нь шинээр II-р одон авах болзол хангах, хэд нь II-р одонгоос I-р одон руу шилжих таамаглалыг тооцоолон гаргасан.

Тооцооллын дүнгээр 50-аас дээш насны нийт 14,557 эх шинээр II-р одон авах болзол хангах, 5,446 эх II-р одонгоос I-р одон руу шилжихээр байна.

Хүснэгт 4. 50-аас дээш насны шинээр II-р одон авах болзол хангах, II-р одонгоос I-р одон руу шилжих эхчүүдийн тоо (тооцооллоор)

Үзүүлэлт	Магадлалын хувь	Эхчүүдийн тоо	Тайлбар
2 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.28%	1,002	II одон шинээр авах
3 хүүхэд амьд & 1 хүүхэд нас барсан (0-1)	3.26%	11,485	II одон шинээр авах
3 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.59%	2,070	II одон шинээр авах
4 хүүхэд амьд & 2 хүүхэд нас барсан (0-1)	0.62%	2,175	I одон руу шилжих
Нийт		20,003	

Эх үүсвэр. Судлаачийн тооцооллоор

³ 15-49 насныхны хувьд багадаа 1 удаа хүүхэд төрүүлсэн хувь 82.2 хувь байсан ба 50-аас дээш насныхны хувьд төрөлт өндөр байсныг харгалзан 97.2 гэж таамагласан.

ДҮГНЭЛТ. Хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор ойролцоогоор нийт 27,140 эхчүүд II одон, 10,154 эхчүүд I одон авах болзол хангахаар байна. Төсвийн тооцооллыг авч үзвэл, нийт 7.5 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардахаар байна.

Хүснэгт 5. Монгол Улсын 15-аас дээш насны шинээр II-р одон авах болзол хангах, II-р одонгоос I-р одон руу шилжих эхчүүдийн тоо (0-1 насандаа нас барсан хүүхдүүдийг нэмж тооцсоноор), нэмэлтээр шаардагдах төсөв (тооцооллоор)

Үзүүлэлт	I, II-р одонгийн болзол хангах эхийн тоо	Нэг эхэд олгох мөнгөн дүн	Шаардлагатай төсөв
	a	b	c=a*b
II-р одон шинээр авах	27,140	200000	5,428,000,000
I-р одон руу шилжих	10,154	200000	2,030,800,000
Нийт	37,294		7,458,800,000

Эх үүсвэр. Судлаачийн тооцоолол

Тайлбар: * - Одонгүй эхчүүд II-р одонгийн 200,000 төгрөг, өмнө нь II-р одонгийн 200,000 төгрөг авдаг байсан эхчүүд I-р одонд шилжиж 400,000 төгрөг авах болзол хангах тул төсөвт мөн адил 200,000 төгрөгөөр нэмж тусгах зөрүүг тооцон гаргасан.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Хуулийн төсөл хэрэгжсэнээр нийтдээ **7.5 тэрбум** төгрөгийн зардал гарах урьдчилсан тооцоо гарч байна. Гэвч энэ нь нийгмийн хамгаалал, хүний эрхийн баталгааг хангах, эдийн засгийн идэвхжил, өрхийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх, үр өгөөжтэй зардал юм. Иймд хууль тогтоомжийн хэрэгжилтийн санхүүжилтийг 2026 оны улсын төсөвт тусган шийдвэрлэх нь зүйтэй.

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2025 он

АГУУЛГА

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

3.1. “Зорилод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

3.2. Практикт хэрэгжих боломжтой байдал шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

3.3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

3.4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Дүгнэлт

4.2. Зөвлөмж

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1, 17 дугаар зүйлийн 17.1-17.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу хийв.

Дээрх аргачлалаар хуулийн төслийн үр нөлөөг тооцохдоо тухайн боловсруулж буй хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно гэж заасан.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ “зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авч судаллаа.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Шалгуур үзүүлэлт	Хуулийн төслийн зүйл, заалт
Зорилгод хүрэх байдал	1 дүгээр зүйл.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 3.2 дахь хэсгийн "бага хүүхэд нь 1 нас хүрсэн" гэснийг тус тус, мөн хэсгийн "байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас", "1 ба түүнээс дээш настай" гэснийг тус тус хассугай. 2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулъя.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх

Дээрх урьдчилсан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Шалгуур үзүүлэлт	Хуулийн төслийн зүйл, заалт
Зорилгод хүрэх байдал	1 дүгээр зүйл.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 3.2 дахь хэсгийн "бага хүүхэд нь 1 нас хүрсэн" гэснийг тус тус, мөн хэсгийн "байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас", "1 ба түүнээс дээш настай" гэснийг тус тус хассугай. 2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 5-д “Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй””, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн

эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “ Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй...” гэж тус тус заасан.

Манай улс төрөлтийг дэмжих, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор залуу үеийг өсгөн хүмүүжүүлэхэд гавьяа байгуулсан олон хүүхэдтэй эхчүүдийг шагнаж байхаар БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор анх 1957 онд “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай” хуулийг баталж, “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгуудыг бий болгож байсан. Энэхүү анхны хууль нь 4 зүйлтэй байснаас 1 дүгээр зүйл буюу Эхийн алдар нэг, хоёрдугаар зэргийн одон бий болгосон шийдвэр нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр байгаа бөгөөд 2 дугаар зүйлийг 2010 онд, 3 болон 4 дүгээр зүйлүүдийг 1962 онд тус тус хүчингүй болгожээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль 2010 онд шинээр батлагдсан. Энэ хуулинд 2011 онд болон 2024 онд нийт 2 удаа нэмэлт хийсэн байна.

Энэхүү хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд “энэ хуулийн үйлчлэлд дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь нэг нас хүрсэн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцлийг хангасан эх” хамаарна гэж заасан бөгөөд мөн хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан “дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй” гэж заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонг, дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонг олгож байна. Ингэхдээ хамгийн бага хүүхэд нь 1 нас хүрэхэд дөрөв болон зургаагаас дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд үрчлэн авсан хүүхдийг хамруулан олгож байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд төрөлтийн хурд буурч байна. Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод хүн амын өсөлтийг жил тутамд 1.7 хувиас багагүй байхаар, 2050 он гэхэд 5 сая хүн амтай болно гэж төлөвлөсөн. Гэтэл сүүлийн жилүүдэд хүн амын өсөлтийн хурд унаж 2020 онд 1.8 хувь байсан бол 2023 онд 1.4 хувь, 2024 онд 1.1 хувь болж, 5 жилийн дотор 0.7 функтээр буурсан байна. Энэхүү статистик үзүүлэлтээс харахад 2050 онд манай улс 5 сая хүн амтай болох боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Хүн ам зүйн чиглэлийн эрдэмтэн судлаачдын хийсэн судалгаагаар манай улс хүн ам зүйн шилжилтийн 3 дугаар үе шатанд байгаа бөгөөд төрөлтийн хурд буурч байгаа энэ нөхцөл байдал хэвээр үргэлжилбэл 2030 он гэхэд насжиж буй нийгэмтэй болох эрсдэлтэй байна. Төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) 1980 онд 6 байсан бол 1990 онд 4.5, 2020 онд 2.9, 2024 онд 2.5 болж буурсаар байна. Энэ байдлаар үргэлжилбэл 2032 он гэхэд ТНК 2 гэсэн түвшинд хүрч цаашид өсөлтгүй тогтвортой буурах нөхцөл үүсэхээр байгааг судлаачид тооцсон байна. Манай улсын ТНК 2005 онд сүүлийн 30 жилийн хугацаан дахь хамгийн бага түвшиндээ хүрч 1.95 хувь болж буурч байсан. Энэ үед хүн амын өсөлтийг дэмжих чиглэлээр олон арга хэмжээг мөнгөн урамшуулал хэлбэрээр авч хэрэгжүүлсэн. Шинэ гэр бүлд 500,000 төгрөг олгох, шинээр төрсөн хүүхдэд мөнгөн тэтгэмж олгох гэх мэт. Энэ шийдлийг тодорхой

судалгаа тооцоонд үндэслээгүйгээс 2012 оноос шинэ гэр бүлд олгодог мөнгөн тэтгэмжийг цуцалсан байдаг. Эдгээр арга хэмжээний үр дүнд төрөлт тодорхой хэмжээгээр нэмэгдсэн ч эдгээр нь урт хугацааны тогтвортой бодлого болон хэрэгжиж чадаагүй байна.

3.2. Практикт хэрэгжих боломжтой байдал шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялсан болно.
29.1.2. Тухай хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн.
29.1.5. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдсөн хэсэг байхгүй;	Хоорондоо зөрчилдсөн хэсэг байхгүй.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Хуулийн төсөл нь нэг удаагийн болон тунхаг шинжтэй зохицуулалтыг агуулаагүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн.

сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	
29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн.

3.3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйл заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлагыг хангасан.
30.1.2. Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн.
30.1.4. Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлагыг хангасан.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлагыг хангасан.

3.4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгуураар хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог үнэллээ. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан

дараах асуудлуудыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэлэлэв.

д/д	Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
1	Хуулийн төслийн зохицуулалт нь тухай хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм
2	Хуулийн төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм
4	Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм
5	Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагыг хангасан.
7	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Үгүй

10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Үгүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөл нь тусгай зөвшөөрөл, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой төсөл биш болно. Иймд шаардлага хангасан байна.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалтыг тусгасан эсэх	Хязгаарласан зохицуулалт тусгаагүй болно. Шаардлагыг хангасан байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Шаардлагыг хангасан.
14	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Шаардлагыг хангасан. Энэ төрлийн зохицуулалт агуулаагүй болно.
15	Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Шаардлагыг хангасан.
16	Хуулийн төсөлд тусгагдсан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Шаардлагыг хангасан.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Дүгнэлт

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг судалж, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу төслийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгээд хуулийн төслийг “үр дүнтэй” гэж үзлээ.